



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/08/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: Б.Ганцэцэг Утас: 70512123
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.5.1 Завсрын аудитын талаар .....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
5.1 Зөвлөмж .....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.24 № 48  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМГИЙН ЦАГДААГИЙН  
ГАЗРЫН ДАРГА Б.БААТАРХҮҮ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Цагдаагийн газрын шинэ конторын барилга ашиглалтад орсон, Байгууллагын түүхт 80 жилийн ой тохиосон. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд аж ахуйн нэгж, албан байгууллага, иргэдийг татан оролцуулах ажлын хүрээнд Аймгийн Засаг даргын 2022 оны А/220 дугаар захирамжаар 7 хоног бүрийн баасан гарагт хуваарийн дагуу олон нийтийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж байна.

### Аудитын гол асуудал

Тус байгууллагын үр дүнгийн тайлангаар нийт зардал 2,748.7 сая төгрөг болж өмнөх оноос 386.9 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь цалин, хөлсний нэмэгдэл, шинэ конторын барилга, Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамгаалах байр шинээр ашиглатанд орсонтой холбоотой байна.

Мөн төсвийн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг ахмадын санд төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 тоот тогтоолын холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

### **Бусад асуудлын хэсэг**

Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын 2022 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 90.6 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>284,589,524.20</u></b>	<b><u>402,143,099.22</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	21,877,796.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	21,877,796.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	21,877,796.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	21,877,796.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	3,910,146.09
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	3,910,146.09
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	66,114,000.00	00.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	66,114,000.00	00.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	66,114,000.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	218,475,524.20	376,355,157.13
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	64,009,760.70	85,509,086.70
35110	Тусгай зориулалттай материал	52,551,030.70	74,184,720.70
35130	Эм боох материал	11,458,730.00	11,324,366.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	88,059,538.50	222,290,854.43
35410	Бичиг хэргийн материал	4,534,520.00	16,265,890.00
35420	Аж ахуйн материал	2,145,120.00	3,636,805.33
35430	Сэлбэг хэрэгсэл	100,000.00	8,406,500.00
35440	Түлш, шатах тослох материал	8,766,485.00	7,933,096.60
35450	Барилгын засварын материал	00.00	83,879,650.00
35460	Хүнсний материал	00.00	6,728,385.00
35470	Бусад хангамжийн материал	72,513,413.50	95,440,527.50
35600	Мал амьтад	66,406,225.00	68,555,216.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,796,746,558.08</u></b>	<b><u>2,029,088,002.04</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,796,746,558.08	2,029,088,002.04
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,549,796,158.08	1,782,227,602.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	982,177,601.00	1,238,470,629.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-107,470,943.58	-145,251,574.83
39203	Авто-тээврийн хэрэгсэл	559,977,511.90	612,177,511.90
39204	Хуримтлагдсан элэгдэл	-251,886,289.36	-322,021,629.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	447,304,254.61	526,304,059.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	-194,233,053.69	-269,418,035.11
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,965,034.80	101,514,134.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,840,449.42	-47,121,607.31
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	42,788,342.78	42,788,342.78
39214	Бусад үндсэн хөрөнгө	57,798,845.75	68,221,845.75
39215	Хуримтлагдсан элэгдэл	-14,784,696.71	-23,436,075.39
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	246,950,400.00	246,860,400.00
39301	Програм хангамж	520,000.00	520,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-430,000.00	-520,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	246,860,400.00	246,860,400.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,081,336,082.28</u></b>	<b><u>2,431,231,101.26</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,081,336,082.28</u></b>	<b><u>2,431,231,101.26</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,081,336,082.28	2,431,231,101.26

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,059,879,285.91	1,059,879,285.91
51101	Өмч: - төрийн	1,059,879,285.91	1,059,879,285.91
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>595,622,676.68</b>	<b>945,517,695.66</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	595,622,676.68	595,622,676.68
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	349,895,018.98
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	425,834,119.69	425,834,119.69
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,081,336,082.28</b>	<b>2,431,231,101.26</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,397,010,371.49</b>	<b>3,098,666,528.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>172,459,895.49</b>	<b>541,430,228.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>172,459,895.49</b>	<b>541,430,228.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,496,695.00	402,258,119.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66,040,875.00	73,678,105.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	7,356,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34,455,820.00	321,223,614.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,224,550,476.00</b>	<b>2,557,236,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,038,860,800.00</b>	<b>2,320,481,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,038,860,800.00	2,320,481,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>185,689,676.00</b>	<b>236,755,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,639,200.00	144,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	240,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	168,050,476.00	92,515,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,361,880,732.62</b>	<b>2,748,771,509.02</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,361,880,732.62</b>	<b>2,748,771,509.02</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,314,334,831.62</b>	<b>2,710,313,688.24</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,713,757,622.00</b>	<b>1,943,440,259.96</b>
210101	Үндсэн цалин	936,456,200.00	1,134,111,068.11
210102	Нэмэгдэл	771,429,612.00	708,912,297.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	7,340,137.14
210104	Урамшуулал	00.00	81,720,019.36
210105	Гэрээт ажлын хөлс	5,871,810.00	11,356,738.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>44,879,230.00</b>	<b>48,681,201.17</b>
210201	Тэтгэврийн даатгал	9,018,330.00	7,172,836.90
210202	Тэтгэмжийн даатгал	769,714.00	26,604.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	942,676.00	21,283.38
210204	Ажилгүйдлийн даатгал	153,941.00	5,320.85
210205	Эрүүл мэндийн даатгал	33,994,569.00	41,455,155.81
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>79,231,696.00</b>	<b>137,312,900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	16,168,108.00	15,835,467.65
210302	Түлш, халаалт	57,846,688.00	117,873,652.35
210303	Цэвэр, бохир ус	5,216,900.00	3,603,780.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	164,329,533.40	186,947,861.07
210401	Бичиг хэрэг	11,534,094.00	18,754,670.00
210402	Тээвэр, шатахуун	108,620,147.00	152,684,288.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,629,284.00	9,632,507.00
210404	Ном, хэвлэл	7,976,400.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	530,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,650,870.00	3,847,366.67
210408	Бараа материал акталсны зардал	18,738,738.40	1,498,629.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	27,139,204.00	42,844,396.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,262,910.00	1,102,906.00
210502	Хоол, хүнс	22,156,294.00	41,651,040.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	720,000.00	90,450.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	49,615,745.00	25,093,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	212,300.00	50,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,193,945.00	2,334,400.00
210604	Урсгал засвар	47,209,500.00	22,709,050.00
<b>2107</b>	<b>Томиллот, зочны зардал</b>	12,246,400.00	13,496,000.00
210702	Дотоод албан томиллот	12,246,400.00	13,496,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	28,146,038.00	109,458,131.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,354,061.00	101,262,820.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,773,089.00	1,014,932.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	374,000.00	443,800.00
210807	Газрын төлбөр	8,492,000.00	4,963,779.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	152,888.00	272,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	194,989,363.22	203,039,489.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,879,667.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,316,580.00	916,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	189,793,116.22	202,123,489.04
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	47,545,901.00	38,457,820.78
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	41,247,602.00	16,900,299.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	30,374,650.00	1,430,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,872,952.00	15,470,299.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	6,298,299.00	21,557,521.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,295,904.00	21,557,521.78
213304	Хөрөнгийн	2,395.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>35,129,638.87</b>	<b>349,895,018.98</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	8,664,359.91	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,664,359.91	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-8,664,359.91	00.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>26,465,278.96</b>	<b>349,895,018.98</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,290,591,351.00</b>	<b>2,657,132,201.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>66,040,875.00</b>	<b>99,895,901.00</b>

<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	66,040,875.00	99,895,901.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	66,040,875.00	99,895,901.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66,040,875.00	73,678,105.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	26,217,796.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,224,550,476.00</b>	<b>2,557,236,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,038,860,800.00	2,320,481,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,038,860,800.00	2,320,481,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	185,689,676.00	236,755,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,639,200.00	144,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	240,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	176,050,476.00	92,515,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,218,020,451.00</b>	<b>2,622,139,385.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,218,020,451.00</b>	<b>2,622,139,385.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,177,187,502.00</b>	<b>2,578,850,353.22</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,716,679,529.00	1,956,955,802.05
210101	Үндсэн цалин	989,359,729.00	1,134,111,068.11
210102	Нэмэгдэл	693,331,100.00	722,427,839.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	7,340,137.14
210104	Урамшуулал	00.00	81,720,019.36
210105	Гэрээт ажлын хөлс	33,988,700.00	11,356,738.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44,836,990.00	48,681,201.17
210201	Тэтгэврийн даатгал	7,979,962.00	7,172,836.90
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	26,604.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	21,283.38
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	5,320.85
210205	Эрүүл мэндийн даатгал	36,857,028.00	41,455,155.81
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	79,231,696.00	137,925,700.00
210301	Гэрэл, цахилгаан	16,168,108.00	15,835,467.65
210302	Түлш, халаалт	57,846,688.00	117,873,652.35
210303	Цэвэр, бохир ус	5,216,900.00	4,216,580.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	148,217,994.00	199,306,077.00
210401	Бичиг хэрэг	12,296,184.00	27,725,800.00
210402	Тээвэр, шатахуун	110,327,956.00	151,850,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,629,284.00	11,500,977.00
210404	Ном, хэвлэл	8,070,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	582,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,714,570.00	7,646,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	31,027,198.00	39,620,442.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,257,560.00	1,218,642.00
210502	Хоол, хүнс	21,359,638.00	36,971,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,410,000.00	1,430,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	122,178,855.00	71,296,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	69,336,600.00	19,164,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,037,155.00	3,813,300.00
210604	Урсгал засвар	47,805,100.00	48,319,000.00

<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	12,246,400.00	13,496,000.00
210702	Дотоод албан томиллолт	12,246,400.00	13,496,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	20,272,060.00	109,185,331.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,632,971.00	101,262,820.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,773,089.00	1,014,932.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	374,000.00	443,800.00
210807	Газрын төлбөр	8,492,000.00	4,963,779.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,496,780.00	2,383,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,496,780.00	2,383,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>40,832,949.00</b>	<b>43,289,031.78</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	34,534,650.00	21,731,510.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	30,374,650.00	10,686,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,160,000.00	11,045,510.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	6,298,299.00	21,557,521.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,295,904.00	21,557,521.78
213304	Хөрөнгийн	2,395.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>72,570,900.00</b>	<b>34,992,816.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>72,570,900.00</b>	<b>13,115,020.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>72,570,900.00</b>	<b>13,115,020.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	72,570,900.00	13,115,020.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	72,570,900.00	13,115,020.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-72,570,900.00</b>	<b>-13,115,020.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	21,877,796.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,059,879,285.91	425,834,119.69	569,157,397.72	00.00	2,054,870,803.32
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,059,879,285.91	425,834,119.69	569,157,397.72	00.00	2,054,870,803.32
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	26,465,278.96	00.00	26,465,278.96
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,059,879,285.91	425,834,119.69	595,622,676.68	00.00	2,081,336,082.28
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,059,879,285.91	425,834,119.69	595,622,676.68	00.00	2,081,336,082.28
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,059,879,285.91	425,834,119.69	595,622,676.68	00.00	2,081,336,082.28
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	349,895,018.98	00.00	349,895,018.98
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,059,879,285.91	425,834,119.69	945,517,695.66	00.00	2,431,231,101.26

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,385,161,700.00	2,372,601,883.22
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,385,161,700.00	2,372,601,883.22
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,367,733,300.00	2,355,210,373.22

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,904,656,300.00	1,892,634,823.05
210101	Үндсэн цалин	1,072,690,100.00	1,069,790,089.11
210102	Нэмэгдэл	737,429,700.00	722,427,839.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,000,000.00	7,340,137.14
210104	Урамшуулал	55,000,000.00	81,720,019.36
210105	Гэрээт ажлын хөлс	33,536,500.00	11,356,738.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	41,253,900.00	41,034,500.17
210201	Тэтгэврийн даатгал	00.00	226,135.90
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	26,604.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	21,283.38
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	5,320.85
210205	Эрүүл мэндийн даатгал	41,253,900.00	40,755,155.81
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	137,925,700.00	137,925,700.00
210301	Гэрэл, цахилгаан	15,010,400.00	15,835,467.65
210302	Түлш, халаалт	117,941,800.00	117,873,652.35
210303	Цэвэр, бохир ус	4,973,500.00	4,216,580.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	170,884,600.00	170,806,077.00
210401	Бичиг хэрэг	24,726,900.00	24,725,800.00
210402	Тээвэр, шатахуун	127,850,900.00	127,850,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,523,900.00	11,500,977.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	636,900.00	582,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,146,000.00	6,146,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	23,191,300.00	23,120,442.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,289,500.00	1,218,642.00
210502	Хоол, хүнс	20,471,800.00	20,471,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,430,000.00	1,430,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	56,632,300.00	56,611,520.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,300,000.00	14,279,220.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,813,300.00	3,813,300.00
210604	Урсгал засвар	38,519,000.00	38,519,000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	13,516,300.00	13,496,000.00
210702	Дотоод албан томиллолт	13,516,300.00	13,496,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	17,289,600.00	17,198,011.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,300,000.00	9,275,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,076,000.00	1,014,932.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	443,800.00	443,800.00
210807	Газрын төлбөр	4,969,800.00	4,963,779.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2383300.00	2383300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,383,300.00	2,383,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	17428400.00	17391510.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	17,428,400.00	17,391,510.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,686,000.00	10,686,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,742,400.00	6,705,510.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,385,161,700.00	2,372,601,883.21
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,320,481,300.00	2,298,923,778.21
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,320,481,300.00	2,298,923,778.21
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	64,680,400.00	73,678,105.00

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,680,400.00	73,678,105.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>106.00</b>	<b>108.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	102.00	104.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>236,755,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>236,755,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		236,755,000.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		64,320,979.00
210101	Үндсэн цалин		64,320,979.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		7,646,701.00
210201	Тэтгэврийн даатгал		6,946,701.00
210205	Эрүүл мэндийн даатгал		700,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		28,500,000.00
210401	Бичиг хэрэг		3,000,000.00
210402	Тээвэр, шатахуун		24,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,500,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		16,500,000.00
210502	Хоол, хүнс		16,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		27,800,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		18,000,000.00
210604	Урсгал засвар		9,800,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		91,987,320.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		91,987,320.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	236755000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		236,755,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		144,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		240,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		92,515,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Цагдаагийн газар “Найдвартай баталгаатай үйлчилгээ-иргэд, олон нийтийн итгэл, дэмжлэг” эрхэм зорилгын хүрээнд хүний эрхийг дээдлэн үйл ажиллагаандаа иргэдийн оролцоо, дэвшилтэт технологийн ашиглалтыг нэмэгдүүлэх болон алба хаагчдын эрүүл мэнд, хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хүний нөөцийн тогтвортой байдлыг бүрдүүлж, ажиллах зорилт тавин иргэдийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж, байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” болон УСНББОУС-тай нийцүүлэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2013 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 422 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 349,895.0 мянган төгрөгөөр буюу 16.8 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
<b>Мөнгөн хөрөнгө</b>	0	21,877.8	21,877.8
<b>Авлага</b>	0	3,910.1	3,910.1
<b>Урьдчилгаа тооцоо</b>	66,114.0	0	-66,114.0
<b>Бараа материал</b>	218,475.5	376,355.2	157,859.6
<b>Үндсэн хөрөнгө</b>	1,796,746.6	2,029,088.0	232,341.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,081,336.1</b>	<b>2,431,231.1</b>	<b>349,895.0</b>
<b>Өр төлбөр</b>	-	-	-
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,081,336.1	2,431,231.1	349,895.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө /Өмчийн дүн/	<b>2,081,336.1</b>	<b>2,431,231.1</b>	<b>349,895.0</b>

- Мөнгөн хөрөнгө данс төрийн сангийн дансанд байрших ахмадын санд төвлөрүүлсэн дансны үлдэгдэл
- Авлага данс НДШ 374.6 мянга, татвар 2,014.6 мянга, албан хаагчаас 1,520.8 мянган төгрөгийн цалингийн авлага үүссэн байна.
- Урьдчилгаа тооцоо дансанд шинээр конторын барилга ашиглалтад орж байгаатай холбоотой тавилга бэлтгэх барилгын материалын үнийг өмнөх онд шилжүүлж тайлант онд хүлээн авсан нь нөлөөлж байна.
- Бараа материал данс 157,859.6 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь өмнөх онд урьдчилгаа тооцоогоор авсан бараа материалыг хүлээн авсан нь нөлөөлжээ.
- Үндсэн хөрөнгө данс 232,341.5 мянган төгрөгөөр өссөн нь ЦЕГ-аас машин, ХЗДХЯ-ны гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Азийн хөгжлийн банкны төслийн санхүүжилтээр түр хамгаалах байр ашиглалтад орж, дансанд бүртгэсэн нөлөөлж байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,585.5 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 2,385.1 мянган төгрөг батлагдсан байна. Энэ нь шинэ конторын байр ашиглалтад орохтой холбоотой тавилга, тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөсөн зардлыг хасаж баталсантай холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,320,481.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 64,680.4 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,320,481.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 73,678.1 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,372.601.8 мянган төгрөг буюу 99.1 хувьтай зарцуулсан байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71704 80101- Үндсэн үйл ажиллагаа	2,385,161.70	2,372,601.88	12,559.81	99.5%
2	71704 80811- Нэмэлт үйл ажиллагаа	236,755.00	236,755.00	-	100%
	НИЙТ	2,621,916.70	2,396,356.88	12,559.81	99.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар олон нийтийн цагдаагийн цалин 95,650.0 мянга, түр хамгаалах байрны урсгал үйл ажиллагааны санхүүжилт 83,750.0 мянга, орон нутгийн

хөгжлийн сангаас гадна гэрэлтүүлгийн санхүүжилт 9,800.0 мянга, зүүн бүсийн наадмын хамгаалалтад аймгаас 42,800.0 мянга, устгал арга хэмжээний зардал 5250.0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авчээ.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг авч үзвэл цалин хөлс 71,967.6 мянган, хангамж материалын зардалд 28,500.0 мянга, хоол хүнсэнд 16,500.0 мянга, багаж техник хэрэгсэлд 27,800.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил үйлчилгээний төлбөрт 91,987.3 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ганцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 43/277 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 2,748,771.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 27,487.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бичиг хэргийн зардал, томилолтын зардал зэрэгт лимит тогтоож зөвхөн гэмт хэрэгтэй тэмцэх албан хаагчдад томилолт олгож байгаа, бусад ажлаар томилолтоор явах болон сургалтад явсан

албан хаагчдад томилолт олгохгүй, ээлжийн амралтаар дотоодын амралт сувиллын газар амрах, төрсөн нутагтаа ирж очих замын зардал олгоогүй, хэвлэл захиалгыг цуцалсан зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4<sup>1</sup> дэх заалтыг мөрдөлгүй 13,115.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан зөрчил илэрсэн. Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1<sup>2</sup> дахь заалтыг мөрдөлгүй хот дотор суудлын автомашин ашигласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8<sup>3</sup> заасныг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь:* Өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд бүрэн гүйцэт, хуулийн хугацаанд мэдээлж байх зөвлөмж өгсөн.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сүхбаатар аймгийн Цагдаагийн газарт завсрын аудит хийгээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар алдаа, зөрчилтэй асуудал илрээгүй байна.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 14,865.5 мянган төгрөгийн 8 алдаа илэрснээс 2 алдааг залруулж, 6 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

<sup>1</sup> Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно;

<sup>2</sup> УИХ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно;

<sup>3</sup> бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

Залруулсан алдаа:

- Бараа материалын тайланд материал, сэлбэг хэрэгслийг нэг бүрийн үнэ, тоо хэмжээ, өртгөөр орлого авч тайлагнаагүй 9,800.0 мянган төгрөгийн материалын тайланг залруулав;
- Аймгийн 80 жилийн ой, Зүүн бүсийн хурд-2022 баяр наадмын хэв журмын хамгаалалтад ажиллах албан хаагчдад хоолны мөнгө олгосон шууд бус орлогыг суутгуулаагүй татварын тайланд шивж залруулав;

## **5.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

*Цахим дэлгүүрт байршсан бараанаас төсвийн худалдан авалтыг зохион байгуулаагүй.*

#### Өгсөн зөвлөмж:

*Төрийн хэмнэлтийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж төсвийн хөрөнгөөр худалдан авах барааг цахим дэлгүүрээс худалдан авч, эрх зүйн актын хэрэгжилтийг хангах.*

#### Илрүүлэлт:

*Төсвийн байгууллагын дарга хот дотор автомашин ашигласан, замын хуудсыг өдөр бүр ямар ажлаар явсныг тодорхой бүртгээгүй, шатахуун олголтод хяналт тавиагүй.*

#### Өгсөн зөвлөмж:

*Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж төсвийн хөрөнгийг үр ашигтай, арвиан хэмнэлттэй зарцуулах*

#### Илрүүлэлт:

*Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг хүргүүлээгүй*

#### Өгсөн зөвлөмж:

*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх*

#### Илрүүлэлт:

*Төсвийн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдээдлийг ахмадын санд төвлөрүүлсэн.*

#### Өгсөн зөвлөмж:

*Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн жил дуусахад төсвийн зарцуулагдаагүй үлдээдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлэх, Засгийн газрын 2017 оны 197 тоот тогтоолын дагуу цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгах*

### **2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 177 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж, хөрөнгийг дахин үнэлэх, актлах саналуудыг эрх байгууллагад хүргүүлэх.

**3. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Өмч, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах тушаал шийдвэрийг шилэн дансны цахим системд байршуулаагүй.

**Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т заасан өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг тухай бүр мэдээлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл												/мянган төгрөг/		
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн		
							Тоо	Дүн	Тоо	Дүн				
Цахим дэлгүүрт байршсан бараанаас төсвийн худалдан авалтыг зохион байгуулаагүй	1	13,115.0			1	13,115.0					1	13,115.0	1	13,115.0
Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 88 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна	1	-			1	-					1	-	1	-
Төсвийн байгууллагын дарга хот дотор автомашин ашигласан, замын хуудсыг өдөр, цаг минутаар нь ямар ажлаар явсныг тодорхой бүртгээгүй, шатахуун олголтод хяналт тавиагүй.	1	5,065.5			1	5,065.5					1	5,065.5	1	5,065.5
Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг хүргүүлээгүй	1	-			1	-					1	-	1	-

Бараа материалын тайланд материал, сэлбэг хэрэгслийг нэг бүрийн үнэ, тоо хэмжээ, өртгөөр орлого авч тайлагнаагүй	1	9,800.0				1	9,800.0			
Аймгийн 80 жилийн ой, Зүүн бүсийн хурд-2022 баяр наадмын хэв журмын хамгаалалтад ажиллах албан хаагчдад хоолны мөнгө олгосон шууд бус орлогыг суутгуулаагүй татварын тайланд тайлагнаагүй	1	1,550.0				1	1,550.0			
Төсвийн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг ахмадын санд төвлөрүүлсэн	1				1	-		1	-	
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>29,530.5</b>			<b>5</b>	<b>18,180.5</b>	<b>2</b>	<b>11,350.0</b>	<b>5</b>	<b>18,180.5</b>

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>									
www.shilendans.gov.mn Өмч, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах тушаал шийдвэрийг тухай бүр байршуулаагүй	1	-						1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>						<b>1</b>	<b>-</b>